

Орон бүхний пролетариат нар нэгдэгтүн!

АНХ ДУГААР

ТАВАНЖИЛ

Төв аймгийн Намын Хороо, А.ДХ-ын гүйцэтгэх захиргааны сонин

27 дахь
жишдээ

№ 67 (2371)

1974 оны 9 дүгээр сарын 9

ДАВАА

мал аж ахуйн өвлийн бэлтгэл

Хүйтэн сэрүүний улирал ойртож мал аж ахуйн өвлийн бэлтгэлийн дутууг яаравчлан хангах цаг боллоо.

Аймгийн хэмжээгээр 700 гаруй мянган малыг отроор таргалуулахдаа нилээд сум Завхан аймгийн туршлагаар «Өргөн айлсалт» зохион байгуулж ажиллах хүчнийг зохицуулан өвлийн бэлтгэлээ хангах малын ашиг шимийг ашиглах ажлыг хугацаанд нь зэрэг хийлээ.

Түүнчлэн бүх сүрэгт зоо-техник, мал эмнэлгийн үзлэг хийж тарга муу авсан болон эмчлэх шаардлагатай малыг тэжээл эмчилгээний цэгт ялган эмчилж тэжээх ажлыг зохион.

Мал аж ахуйн өвлийн бэлтгэлийн чухал хэсэг байгалийн хадлан 95,7 мянган тонн бэлтгэхээс одоогийн байдлаар 64 мянга гаруй тонныг бэлтгээд байна.

Жаргалантын САА, Баян-Өнжүүл сумын «Хайрхан» нэгдэл хадлангийн ажлыг шуурхай зохион байгуулан ажилласнаар төлөвлөгөөг 102—102,7 хувиар биелүүлж, Лун сумын «Энх-туул», Эрдэнэ сумын «Туяа» нэгдэл хадсан өвснийхээ 50,9—58,0 хувийг өвөлжөө хаваржаандаа татаж хамгааллаа.

Аймгийн хэмжээгээр 119 хашаа шинээр барихаас 84 хашаа барьсаны дотор Баянцогт, Борнуур, Баян-Өнжүүл, Сэргэлэн зэрэг 9 сум энэ оны хашаа барих төлөвлөгөөг биелүүллээ.

Баянцогт, Баянзүрх, Баян-Өнжүүл, Баянцагаан сумд энгийн уурхайн худгийн төлөвлөгөөг 100—150 хувиар биелүүллээ.

Гэвч Баянжаргалан, Баяндэлгэр, Баян сумын хадлангийн төлөвлөгөө дөнгөж 14,7—44,5 хувьтай. Бүрэн зэрэг 6 сум энгийн уурхайн худгийн 28,6—42,9 хувийг гаргаж, Эрдэнэсант, Борнуур зэрэг 10 шахам сум хадсан өвсөө өвөлжөө хаваржаа фондондоо татаж хамгаалах ажлыг одоо болтол хийгээгүй байна.

Нийт сумд өвлийн бэлтгэл ажлыг суурь бүрийн өвлийн бэлтгэлийг хангуулахаас эхлэн нарийн төлөвлөгөө гарган зохион байгуулалтын тодорхой арга хэмжээ авч ажиллах хэрэгтэй.

Бэлтгэсэн өвс тэжээл өтөг бууцны хүрэлцэх хэмжээ, нөөцийг суурь бригад бүрээр тооцож хэрэгцээгээ илүү гарсан төлөвлөлийг бусад суурьт шилжүүлэх, буслаас худалдаж авах тэжээлийг эртнээс өвөлжөө хаваржаандаа татах нь чухал.

Хашаа саравчны дулаалга муугаас хэвтэр хөлдөж, мал даарч зутран хээл хаях, хотондоо хивлэг гүйцэд авч чадахгүй зэргээс эцэж турдгийг малчин анхаарч энэ ажлыг яаравчлан хийх нь зүйтэй.

Өвлийн отрыг нарийн зохион байгуулж оторчдыг дулаан хувцас дах дэгтий, отрын гэрээр бүрэн хангаж үйлчилгээг тогтмолжуулах арга хэмжээг сум бүр эртнээс авах хэрэгтэй. Суурийн сургууль, бригадын өдөрлөг, семинар зөвлөлгөөн, тэргүүн туршлагын үзүүлэх сургууль хийж мал тэжээх тэжээлийг зөв зарцуулах, хашаа байр, хэвтрийг дулаалах, худаг, уст цэгийг засварлах, тохижуулах ажлыг тэргүүний малчдын туршлага, дэвшилттэй арга барилыг малчдад эзэмшүүлэх ажил зохиовол зохино.

Өвөлжөөний бэлчээрийг ашиглах хуваарийг суурь нэг бүрээр гаргуулж тэжээх шаардлагатай малыг эртнээс тэжээлд оруулах хэрэгтэй. Мал аж ахуйн өвлийн бэлтгэлийг бригад суурнаас, сум бригадаас, аймаг сумаас хүлээн авч дутагдалтай зүйлийг тэр дор нь гүйцээх арга хэмжээг авч ажиллах нь чухал.

Мал аж ахуйн өвөлжилтийг зөв зохион байгуулж мал сүргээ тарган тавтай онд оруулахад нам, уулс, ХАА-н байгууллага, мал аж ахуйн мэргэжилтэн, малчин бүр анхаарч ажиллавал зохино.

Баян-өнжүүлийнхний амжилт

Баян-өнжүүл сумын хадланчид 9 дүгээр сарын 1-ний дотор 3210 тонн өвс хадаж 110 мянган ширхэг таанан зоодой хийж хадлангийн төлөвлөгөөг 107 хувь, зоодой бэлтгэх төлөвлөгөөг даалгаврыг 110 хувиар биелүүллээ. Хадлан өвс бэлтгэх ажилд Шараа ахлагчтай механикжсан салааны хадагч Наваантаяа, Ядамсүрэн нар 351—428 тонн өвс хадаж, Мямаржав, Наянтай нар 834—953 тонн өвс тармаж сайхан амжилт гаргалаа. Тус сумын хүний их эмчийн салбар, Ясли, Цэцэрлэг, ХБ анги, гуанз, Зочид буудал, авто граж зэрэг байгууллагууд 7000—10000 зоодой хийж албан байгууллагынхаа хаягтайгаар хайраглан савлаж нэгдэлдээ тушаалаа.

Э. БУЯННЭМЭХ
Ц. ЖАДАМБАА

Аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас ХАА-н нэгдэл, САА, ТАА-н тэмээчин, адуучин, үхэрчин нарт илгээсэн ЗАХИДАЛ

Аймгийн АДХ-ын 10 дахь удаагийн сонгуулийн VI чуулганаар бод малын тогтвортой өсөлтийг хангах арга хэмжээний тухай хэлэлцэх гэж байгаагаар холбогдуулж, аймгийн нийт тэмээчин, адуучин, үхэрчин та бүгдийн амрыг эрэн мэндчилж энэхүү албан захидалыг илгээв.

Аймгийн нийт малын 0,8 хувийг тэмээ, 12,6 хувийг адуу, 12,2 хувийг үхэр эзэлдэг бөгөөд мал аж ахуйн мөнгөн орлогын 5,4 хувийг тэмээний, 11,2 хувийг адууны, 23 хувийг үхрийн аж ахуйгаас оруулж жилдээ улсад 10 гаруй сая литр сүү, 1 сая литр айраг, 3 мянган тонн үхрийн мах, олон мянган агт тушааж байна.

Ард түмний аж байдалыг сайжруулах, улс орны эдийн засгийн хүч чадлыг нэмэгдүүлэхэд чухал суурь эзэлдэг бод малыг өсгөж, ашиг шимийг нь дээшлүүлэх талаар нам засгаас цаг ямагт анхаарч байгаа юм.

Үүний т о д илрэл нь МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлөөс зөвхөн 1973—1974 онд, малын зүй бүс хорогдлыг багасгаж, «тэмээний сүргийг өсгөх», «Үнээ, гүүний хээлтүүлгийн ажлыг хугацаанд нь чанар сайтай явуулж, сувайр а л т ы г багасгах», «Цөгийн тос, цагаан идээ үйлдвэрлэх ажлыг сайжруулах зарим арга хэмжээний тухай» зэрэг хэд хэдэн чухал тогтоол гаргалаа.

Нам, засгаас авч явуулж буй эдгээр арга хэмжээ, та нарын шуруугуу бүтээлч хөдөлмөрийн үр дүнд манай аймаг цэвэр болон сайжирсан үүлдрийн 16,9 мянган үхэртэй б о л ж жилдээ н э г үнээгээс 1700—2100 литр сүү сааж Улаанбаатар хот болон аймгийн хөдөлмөрдийг сүү ба сүүн бүтээгдэхүүнээр хангах нэр төртэй үүргээ амжилттай биелүүлсээр байна.

Манай тэмээчин, адуучин, үхэрчдийн дотроос үнээ бүрээс 3500—4000 литр сүү саасан Батсүмбэрийн САА-н саальчин, БНМАУ-ын хөдөлмөрийн баатар А. Авирмэд, хариуцан малладаг нийгмийн ингэнээс 600 гаруй богтоосон мэнд бойжуулсан

Баян сумын «Цацралт» нэгдлийн тэмээчин улсын аварга малчин А.Балдан, эрлийз ү н э э бүрээс 2117 литр сүү саасан Батсүмбэрийн САА-н саальчин, улсын аварга малчин Ц. Хорлоо болон Эрдэнэ сумын «Туяа» нэгдлийн үхэрчин, аймгийн аварга, энх сүрэгтэн Д. Осоржам, Эрдэнэсант сумын «Саруул-амьдрал» нэгдлийн адуучин, аймгийн аварга Н. Цэдэвдорж нарын зэрэг ажил хөдөлмөрөөрөө тодорсон БНМАУ-ын хөдөлмөрийн баатар 3, БНМАУ-ын аварга малчин 7, аймгийн аварга малчин 63 манай тэмээчинд, адуучид, үхэрчдийн дундаас төрөн гарлаа.

Гэвч МАХН-ын Төв Хорооны VIII бүгд хурлаас 100 хээлтэгч тутмаас бойжуулах төлийн талаар тавьсан зорилтыг ботго-

ноос бусад төл дээр сүүлийн 3 жил дараалан тасалж унага 5—19, тугал 8—12-оор тус тус доогуур бойжуулж байгаа нь бод малын өсөлтөд муугаар н ө л ө л ж төл бойжуулах таван жилийн төлөвлөгөө тасрахад хүрч байгаагийн дээр зүй бүс хорогдол үлэмж хэмжээгээр гарч байснаас бод малын өсөлтийн хурдац сүүлийн жилүүдэд удааширч байна.

Аймгийн хэмжээгээр тэмээ, адуу өсгөх төлөвлөгөө сүүлийн 10 жилийн 7 жилд нь, үхэр өсгөх төлөвлөгөө 8 жилд нь тасарч одоо 1975 оны хөдөлмөрийн төлөвлөгөөнөөс тэмээ 404, адуу 29300, үхэр 32800 дутуу байна.

Бод малын өсөлт ингээж хангалтгүй байгаагийн шалтгаан нь:

—Малын хариуцлага, маллагаа муу, отор бэлчээрээр малаа сайтар таргалуулж, авсан таргыг тогтоох ажлыг малчин бүр жигд хийхгүй, бод малын үржил хээлтүүлгийн ажлын эмх цэгц зохион байгуулалт хангалтгүй байна.

—Тэмээ, адууг шилбэ, дааганд нь сургахгүй эмнэгшүүлэх, тэмээ, адуу, үхрийг хоньчлон харуулахгүй байгаагаас олон тоогоор алдагдах, чононд идүүлэх, гэнэтийн шуурга, цас бороонд нэрвэгдэж үхэх явдал их байна.

—Ихэнх буур, ингэ эмнэг учраас ингэ хээл-

түүлгийн үед ингэ нэг бүрт буур суулгаж чадахгүй, ботгодох ингэ бүрийг байнгын хариуцлага манаатай байлган, шилбэг алдахаас хамгаалан ботгыг гардан авдаг зэрэг, манай малчин а р д ы н уламжлалт аргыг орхигдуулж байна.

—Адууг хэтэрхий олноор суурилан зуны улиралд хот орчимд гүү барихдаа азаргагүй ирүүлж саадаг, байдсан гүүг эх сүргээс нь тэр бүр ялгахгүй, хээлтүүлгийн үед адууг азарга азаргаар нь ялган хариулахгүй, өвлийн оторт эртнээс бэлтгэл з о х и о н байгуулалттай гаргахгүй, цаг оройтсон хойно, бог малын бэлчээрийг чөлөөлөхийн тулд ийш тийш нь хөөж олноор хээл хауулдаг явдал их байна.

—Үнээг зохиомлоор хээлтүүлэх арга зааврыг нарийн баримтлахгүй, хээлтүүлгийн с ү л и й н үеийн дэвшилт аргуудыг бүрэн хэрэглэхгүй байгаагаас жил тутам олон тооны үнээ сувайрч, бас хээл хаяж тугал хорогдгоор явдал гарсаар байна.

Ийм учраас 1974 онд аймгийн хэмжээгээр мал өсгөх төлөвлөгөөг төрөл бүр дээр нь биелүүлэн, толгойн дүнгээр 1975 онд байх малын хэмжээнд хүргэхээр аймгийн намын XVI бага хурлаас дэвшүүлсэн зорилтыг хэрэгж ү ү л э н биелүүлэхэд шийдвэрлэх асуудал болсон бод малын өсөлтийг хангахад онцгой анхаарч а ж и л а х ы н хамт уг асуудлыг аймгийн чуулганаар хэлэлцэж авах арга хэмжээний талаар оновчтой санал зөвлөгөө өгөхийг хүсч алдарт малчин танарт дор дурьдсан зөвлөмжийг өгч байна. Үүнд:

1. Нийгэм ба амины малаа энэ онд заавал өсгөх хүндтэй бөгөөд хариуцлагатай үүргээ амжилттай биелүүлэхийн тулд суурь бүр намын оторт хөнгөн орон сууцтай гарч, бод мал бүрдээ дундаас дээш тарга хүч авахуулан, авсан тарга хүчийг чамбайруулан тогтоож нэг ч малыг зүй бусаар хороолгүй ажилласан амжилтаар аймгийнхаа чуулганд бэлэг барьц-

(Төгсгөл нь II нүүрт)

Аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас ХАА-н нэгдэл, САА, ТАА-н тэмээчин, адуучин, үхэрчин нарт илгээсэн ЗАХИДАЛ

Төгсгөл. (Түрүүч нь
I пүүрт)

гаана гэдэгт итгэж байна.

2. Суурь бүр 10 дугаар сард багтаан БНМАУ-ын ХАА-н Нэгдлийн Холбооны Дээд Зөвлөлөөс тогтоосон журмын дагуу нийгмийн бүх тэмээ, адуугаа тамгатай, үхрийг имтэй болгохын хамт цэвэр, сайжирсан үүлдрийн болон нутгийн шилмэл үхрийн эвэр, туурайд хувийн номер тавьж картжуулаад, адуу, тэмээг зүсмийн данстай болгож цаашид улирал, жилийн тооллогыг им, тамга, зүсмийн дансаар нь тулган тоолуулдаг журамтай болох.

3. Үнээ, тугал, өсвөрийн насны үхрийн дундаар байр хэвтрийн хангамжийг улам сайжруулан тором, ботготой, хээл тэй ингэ бүрийг саравч-

тай хашаагаар хангах ажлыг онцлон анхаарч өөрсдөө санаачлан ялангуяа аймгийн чуулганы наана сум бүр тэмээний хашаа 1—2-ыг барьж хашаа хэвтрийг бууцжуулсан байвал зохино.

4. Бод малыг жилийн 4 улиралд байнга хоньчлон хариулдаг аргыг байнгын хэвшил болгон адуучин бүр адуугаа шөнийн цагт ээлжээр манаж өглөө нь адуугаа албан ёсоор хүлээлцдэг журамтай болох.

5. Малчин бүр энх сүрэгтэн байхын тулд чармайн тус бүр нэг тэргүүний тэмээчин, адуучин, үхэрчний туршлагыг цохон эзэмших хэрэгтэй.

6. Малдаа өдөр бүр ажиглалт үзлэг хийж өвчин эмгэг туссан сульд и н доройтсон тэмээ, адуу, үхрээ цаг алдалгүй тэжээл эмчилгээний

цэгт ялгаж эмчлэн эдгэруулж тэжээж тэнхрүүлж байх нь мал хороохгүй байхын нэг нөхцөл мөн.

7. Суурь бүр үнээ, гүүний хээлтүүлгийн журнал, үнээ хээлтүүлгийн хуанлитай болж үлгэр жишээчээр хөтлөхийн хамт саалийн суурь бүр эргэлтийн төлөөлтийн журналыг сар сараар хөтлөн дүгнэдэг болцгооё.

8. Одоо хээл аваагүй байгаа үнээ бүрийг гардан болон зохиомол аргаар 8, 9 дүгээр сард багтаан заавал хээлтүүлж, авсан хээл бүрийг бүрэн хамгаалж ажиллацгаая.

9. Суурь бүр тугалаа өглөө, оройн сэрүүнд, үнээгээ шөнийн бэлчээрт харнулах зэргээр тугалаа

махлуулах, үнээний сүүний гарцыг нэмэгдүүлэх талаар онцгой анхааръя.

10. Зааз тэмээ, адуу, үхрийг бэлчээрийн аргаар таргалуулан, идшинд хэрэглэх малын заримыг аль болохоор хэмнэж, сүү цагаан идээг өргөн хэрэглэж, оны эцэст тоолуулах нийгмийн ба амины бол мал өсгөх даалгаврыг суурь бүрт 3-аас доошгүй малаар давуулан биелүүлэхийг аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргаа эрхэмлэн та нарт итгэж, энэ итгэлийг бүрэн биелүүлэх боломжтой болсноо, аймгийн АДХ-ын чуулганд илэрхийлсэн рапорт захидлаа ирүүлнэ гэдэгт найдаж байна.

АЙМГИЙН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГАА


1974 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр

Зуунмод хот.

ТӨЛӨВЛӨГӨӨТ ТАВАН ЖИЛИЙН ГАВШГАЙЧ

Алтаибулаг сумын "Ходолмор" нэгдлийн саяльчин, аймгийн намын бүгд хурлын гишүүн Д. Чинбат V таван жилийн төлөвлөгөөг хугацаанаас нь 2 жил 3 сарын өмнө биелүүлсэн амжилтаар хамт олноо үлгэрлэн амжиллаж байна.

Л. ГУНГААБУУ-гийн авсан гэрэл зураг



УРГАЦ ХУРААЛТ-ХЯНАЛТ ШАЛГАЛТ

Улс ардын аж ахуй соёлыг хөгжүүлэх V таван жилийн төлөвлөгөөг биелүүлэх бат суурь дэвсгэр жил-1974 онд газар тариалангийн талаар тавьсан зорилтыг биелүүлэхийн тулд сум-нэгдэл, САА, нийт тариаланчид арвин их ургац хураан авах явдал юм.

Саяхан МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл МҮЭ-ийн Төв Зөвлөл, 1974 онд улс ад тушаах үр тариа, төмс, ногоо, фондын өвсний төлөвлөгөөг биелүүлэх талаар социалист уралдаан зарлаж чухал болзол гаргасан нь манай орны тариаланч хэлдэг САА, ТАА, ХАА-н нэгдэл тэдгээрийн тасаг, бригад, тариаланч, механикжуулагчдын хөдөлмөрийн идэвх урам зоригийг өрнүүлж байна.

Иймээс үр тариа, төмс, хүнсний ногоог хаягдалгүй хураахад чиглэгдсэн

хяналт шалгалтыг АХШБ голлож урьдах жилүүдийн туршлага дээр тулгуурлаж зохион явуулах цаг боллоо.

Олонх нэгдэл, САА-д ургац хураалтын төлөвлөгөө биелэх эсэх нь тариаг хаягдалгүй хурааж авахтай холбоотой бөгөөд хяналт шалгалтын ажил шийдвэрлэх үүрэгтэй. Иймд тариа ногоо хураалтын явц, талбай, үтрэм болон тээвэрлэлт, тушаалт, хадах техникийн тохируулгаар хаягдал гаргахгүй байхад чиглэгдсэн бүх шалгалтыг хураалт эхлэхээс дуусгалах хугацаанд далайцтай зохион явуулж чимх будаа, ширхэг төмс, ногоо гээгдүүлэхгүйн төлөө тавих тэмцлийг эрчимжүүлэн ургацын төлөвлөгөөг биелүүлэхэд ардын хяналтын байгууллага бүх ажлаа чиглүүлбэл зохино.

Хянан шалгагчид хаягдал гарч байгаа эсэхэд талбай, үтрэм, агуулах, бригад, тасгуудаар зөвхөн нэг удаа шалгах биш тусгай графикаар байнга шалгалт хийх нь чухал бөгөөд комбайны тохируулгыг нарийн хийлгэж, авто машины тэвшийг тариа гоожихооргүй болгосон байх шаардлагатай.

Тариаг хадсан ба цайруулсан талбай бүрээр явж дэл далан үлдээсэн эсэхийг шалгаж авто машины замын бартааг засуулсан байх хэрэгтэй. Түүнчилэн үтрэм дээр будаа ялзарч байгаа эсэх, цэвэрлээд ашиглаж болох будааг хаяж байгаа эсэхэд шалгалт хийж илэрсэн дутагдлыг дор бүр нь засуулбал зохино.

Төмс ногоо хураасан талбайн ил далд үлдсэн хаягдлыг олж авахуулан өдрийн хийсэн шалгалтын дүнг радиогоор ярих, мэдээлэх хуудас гаргах тариа ногооны хаягдлыг

тооцоолон үнэ өртөгт шилжүүлж хаягдалгүй хураахад олны идэвхи хөдөлгөөнийг өрнүүлэх олон талын ажил зохиож хаягдал гаргаагүй комбайнчин, ногоочдод баяр хүргэх, дутагдал гаргагчдад тодорхой арга хэмжээ авч ажиллах ёстой.

Ингэхдээ нэгдэл-САА-нуудын тариа ногооны бүх талбайг хяналт шалгалтад хамруулах зорилгоор зөвхөн тариа хураалтын үед ардын хянан шалгах постыг шинээр байгуулан ажиллуулж болно.

Ингэхдээ өндөр насны тэтгэвэр авагчид, пионер сурагчид, оюутан, залуучууд, АХШ хороо, групп постын гишүүдийг хамран ажиллуулж тэдэнд тодорхой талбайг хариуцуулж өгөөд байнгын үзлэг шалгалт хийлгэж шалгалтын дүнг өдөр тутам хамт олонд нь сонсож, мэдээлэл гаргуулж байх нь зүйтэй.

Тариа ногоо, өвс хад-

ОТРЫН БЭЛЧЭЭРТ

Малаа отроор таргалуулах талаар туршлага суусан тэргүүний малчид Лун суманд олон бий.

Өгөөмөр, Хангайн ар, Хөшгийн өврөөр малчин Бат, Жунай, Цэрэндулам, Доржханд нарын олон малчидтай отрын бэлчээрт нь уулзлаа.

Хоньчин Д. Цэрэндорж сүүлийн 10 жил сувай ба төллөх 580—650 хонь хариуцан маллаж жил бүр төл бойжуулалт, ноосны төлөвлөгөөг 100,4—102,4 хувиар биелүүлж иржээ.

Малдаа тарга авахуулах нь амжилтын үндэс гэж үздэг Д. Цэрэндорж жилийн эхэнд отрын нарийн хуваарь хийж бэлтгэлээ сайн хангадаг аж.

Ингэж ажиллагсаас эдний эм хонины дундаж жин сүүлийн жилүүдэд 56—58 кг-д тогтмол хүрдэг болжээ.

Энэ онд 579 хониноос 579 хурга бойжуулж, төл бойжуулах талаар МАХН-ын Төв Хорооны IX бүгд хурлаас дэвшүүлсэн зорилтыг 3 дахь жилдээ хангалаа.

Ноос, ноолуур хялгасын төлөвлөгөөг 2,6—7,8 кг-аар давуулжээ.

Үхэрчин Бат аймгийн 2 удаагийн аварга хүн.

Бэлчээрээр үхрийг таргалуулахад уулархаг ба тал газар усны тунгалайг сонгодог ажээ.

Энэчилэн үхэрчин Доржханд, Жунай нар отроор малаа сайн таргалуулдаг малчид юм.

Үхэрчин Жунайг олоо зоодой, дарш зэрэг гар тэжээл их хэмжээгээр бэлтгэн нөөцлөж байгаа аж.

Л. БАТСУХ

ланг хаягдалгүй авсан талбайд улаан дарцаг, хаягдал гарсан талбайд хөх дарцаг хатгаж хаяж гэсэн ургацыг дахин авахуулах зэргээр хянан шалгах байгууллагаас хийх ажлыг өндөржүүлэх хэрэгтэй.

Тариа ногооны хаягдлын талаар АХШ хороо, групп хурлаараа хэлэлцэх, шаардах хуудас бичих, хохиролтой гэж үзвэл төлбөр тавих болон уралдаан дүгнэхэд хаягдлын талаар АХШ хороо, групп саналаа оруулах зэрэг зохион байгуулалтын арга хэмжээг авч байх ёстой.

Тариа хураалтын явцад нэгдлийн зөвлөл, САА-н захиргаа, олон нийтийн байгууллага, мэргэжилтэн нар байнга хяналт тавьж бичлэн удирдаж илэрсэн дутагдлыг тухай бүрт нь арилгах талаар эрс шийдвэртэй арга хэмжээ авч ажиллах нь чухал байна.

Б. БАЛГАНСҮРЭН

Социалист хувьсгалынх нь 30 жилийн ой

БҮГД НАЙРАМДАХ БОЛГАР АРД УЛС

Зөвлөлтийн ялгуулсан улаан армийн давшиж байсан 1944 оны есдүгээр сард коммунистуудаараа манлайлуулсан Болгарын ард түмэн монарх-фашистын засгийг түлхэн унагаажээ. Социалист хувьсгал нь Болгар оронд шинэ амьдралыг зохион байгуулах өргөн бололцоог олгосон юм.

Коммунист намаараа удирдуулсан Болгарын ард түмэн хүнд бэрхшээлийг даван туулж ЗХУ болон ах дүү социалист бусад орнуудын чин сэтгэлийн тусламж дэмжлэгтэйгээр гурван арван жилд социалист нийгмийг амжилттай байгуулж байна. БНБАУ нь 110,9 мянган хавтгай дөрвөлжин км газар нутаг, 8,6 сая хүн амтай бөгөөд хүмүүсийн 4,8 сая нь хотод, 3,8 сая нь хөдөөд суудаг.

Тус улсын үндсний орлого 1950-1973 онд 7,4 дахин, 1973 онд урьд оныхоос 8,7 хувиар нэмэгдэж 1975 онд 1970 оныхоос 50 хувиар өснө.

Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн 1950-1973 онд 15,4 дахин өсч 1975 онд 1970 оныхоос 55-60 хувиар нэмэгдэх юм.

Улс ардын аж ахуйд оруулсан хөрөнгө оруулалт 1951-1973 онд 13 дахин, 1950-1972 онд хөдөө аж ахуй, ойн аж ахуйд оруулсан хөрөнгө 17 дахин өсчээ.

БНБАУ цахилгаан болон авто өргөгч кран үйлдвэрлэлтээр дэлхийд III байранд ордог юм.

Машины бүтээгдэхүүнийг 1975 онд 1970 оныхоос 2 гаруй дахин нэмэгдүүлэхээс гадна холбооны янз бүрийн техник

хэрэгсэл, радиогийн цахилгаан тоног төхөөрөмжийг амжилттай хөгжүүлж байна.

Цахилгаан багаж хэрэгсэлийн үйлдвэрлэл сүүлийн 3 жилд 1,8 дахин өсөв.

Тус орны боловсруулж байгаа газрын 93 хувийг хамарсан газар тариалан аж үйлдвэрийн 170 том нэгдэл байгуулагджээ.

Хүн ам тутамд ноогдож байгаа тамхи, жимс, эрдэнэ шиш, наран цэцэг, арвай, улаан буудай үйлдвэрлэлээрээ дэлхийн тэргүүний орнуудын нэг нь болжээ.

1974 онд Болгарын хоршоолгогчид ХАА-н хүнд хүчир хөдөлмөрийг хөнгөвчилсөн Зөвлөлтийн «Нива», «СК-5», «Колос» зэрэг комбайн нэг мянга гаруй, мөн Чехославакт

үйлдвэрлэсэн өндөр бүтээлтэй ачигч зэрэг 14 нэр төрлийн шинэ машин техникийг хүлээн авчээ.

БНБАУ эдийн засгийн хөгжилт бэхжилтийн үрээр өнгөрсөн онд 1,5 сая хөдөлмөрдийн цалин нэмэгдэж ихэнхи тойргууд ажлын таван өдөртэй долоо хоногт шилжиж жижиг лэн худалдаалах таворын эргэлт 8,6 сууцны барилга 18,9, хүн ам тутмын бодит орлого 7,9 хувиар тус тус нэмэгджээ.

Ардын засгийн жилүүдэд 1 сая 200 мянган сууцны барилга баригдсац бөгөөд сүүлийн 12 жилд тосгоны сууцны фондын 80 гаруй хувь нь шинэчлэгдэв.

БНБАУ ард түмний эмнэлгийн үйлчилгээгээр дэлхийд тэргүүний байранд ордог бөгөөд 1972 онд нэг их эмчид 500 хүн ноогдож байв.

Нийтээр 8 жилийн ерөн

хий боловсрол эзэмших ажилд шилжээд улмаар политехникийн дунд боловсрол эзэмших зорилттой ажиллаж байгаагийн дээр их, дээд сургуульд 1,5 сая хүн суралцаж байна.

БНБАУ-ын гадаад худалдааны эргэлтэд ЗХУ 1 дүгээр байр, ЗХУ-ын гадаад худалдааны эргэлтэд БНБАУ IV байрыг тус тус эзэлж байна.

Тус хоёр орон 1974 онд 2,8 миллиард рублийн бараа харилцан нийлүүлжээ.

Зөвлөлтийн 41, Болгарын 13 яам тусгай газар, Зөвлөлтийн 163, Болгарын 100 эрдэм шинжилгээний хүрээлэн байгууллагууд үйлдвэрлэлийн зангилаа эрдэм шинжилгээний 460 ажлыг туурвихаар шинжилгээ судалгааны ажлыг хамтран хийж байна.

Н. ХАНДСҮРЭН

НЭГ САЛААНЫХАН

МАХН-ын гишүүн ногоочин Д. Доржпалам сүүлийн 10 гаруй жил хүнсний төрөл бүрийн ногоо тариалж арвин туршлага хуримтлуулж амжилтанд хүрч яваа хүн.

Тэрээр Шунхлайн булгийг ашиглан салааныхаа ногоочдын хүчээр хоёр км суваг татаж түүгээрээ 16 га газрын хүнсний ногоог усжуулжээ.

Мөн Доржпалам, П.Өлзийбуян, Д. Ичинхорлоо, Д. Жамъян нарын 20-иод хүнийг дагалдуулан сургаж тэдний дундаас аймга сумандаа нэр цуутай хөдөлмөрийн сайчуул олныг төрүүлж байна.

Энэ жил ургац хураах төлөвлөгөөгөө салааны хэмжээгээр хорин хувиар давуулан биелүүлж арвин ургац хураан авах боломжийг олж авад байна.

Түүний ярьсан нь Манай салааныхан энэ онд хүнсний ногоо тариалах талбайг орон нутгийн бордоогоор га тутамд 25-30 тонноор бордож үрслэг бойжуулах ажлыг хугацаанд нь чанартай хийж орон нутгийн онцлогт тохируулан ил хөрсөнд шилжүүлж суулган тариалж дараахь бут нэг бүрийг шалгаж нөхөн суулгалтыг хийж ургацны хугацаанд усалгааг 4-7 удаа хийж, эрдэс болон орон нутгийн бордоог нэ-

мэгдэл бордоо болгон хэрэглэх, бууц сангасыг исгэж ашиглах, зэрлэг ургамлыг 3-4 удаа устгаж хөрснийг 1-2 удаа сийрүүлэх зэргээр агротехникийн дэс дараалсан арга хэмжээг авч явуулснаар жил дараалан арвин ургац авч байна гэв.

Эдний салааныхан тарьж ургуулсан ургацаа гэнэтийн хүйтрэлт ба хяруунаас хамгаалахын тулд утаа тавих бэлтгэлийг үрдчилэн хангаж, ногоочид хяруу хүйтрэлт болох үед нэгдсэн дохиогоор ажиллах, хүн бүрт утаа тавих цэгүүдийг хуваарилан өгөх зэрэг зохион байгуулалтын арга хэмжээ авсан нь ургацын төлөвлөгөөг давуулан биелүүлэх нөхцлийг бүрдүүлж байна.

Тус салааны ахмад ногоочин Д. Өлзийбуян олон жил байцаа тариалж арвин их ургац авдаг туршлагаа бататган 1974 онд га газрын байцаа харуцан ажиллаж 350 центнер ургац хураан авч үүрэг авч амласан үүргээ хэрэгжүүлэн эрт ургацын ногоогоор сум орон нутгийн хэрэгцээг хангаж га газраас 40 тонн ургац хураан авч байна.

Ногоочин Доржпаламын охин илгээлгийн эзэн

Ренчинхорлоо, Ренчинханд нар аавынхаа хүнсний ногоо тариалаг туршлагыг эзэмшиж байгаа, сонгинын талбайг хариуцан ажиллаж аричлгаа усалгаа тордолтыг чанар сайтай хийж уйгагүй ажилласны үрээр ургац хураах төлөвлөгөөг 120-200 хувиар биелүүлэн бусад ногоочдоо хошуучилж байна.

Ногоочин Ренчинханд ургацыг нэмэгдүүлэхийн тулд ургалтын хугацааны дунд үеэс хойш талбайн хөрсийг сийрүүлэн суллаж сонгинын булцууг ил гарган цоорыг нугалсан явдал булцууг томруулан ургацыг нэмэгдүүлэх нөхцлийг хангажээ.

Энэ ногоочин 14 тонн ургац авахаас 20 тонн ургац хурааж байна.

Тус салааныхан хамтын хүчээр 50 тонн үрийн төмс хадгалах галлагаатай зорилгыг барьж ашигдалд оруулсан нь орон нутгийн онцлогт тохирсон нутагшсан сортын үрээр тариалах бүрэн бололцоотой болжээ.

Ингэж Архустын ТАА-н ногоочин Д. Доржпаламын салааныхан МАХН-ын III их хурал хуралдсаны болон БНМАУ-ыг тунхагласны 50 жил, атар газар эзэмшсэний 15 жилийн ойнуудыг ажлын өндөр амжилтаар угтаж байна.

МАНАЙ СУРВАЛЖЛАГЧ

АРМИЙН ДАЙЧИД МЭНДЧИЛЖ БАЙНА

Ажил үйлсээрээ алдаршсан алтан нутгийнхандаа ардын армийн дайчдын мөнхийг дэвшүүлэе.

Олон аавын хөвгүүдтэй мөр нийлүүлэн жагсаж, хөл нийлүүлэн алхаж эх орноо батлан хамгаалах ариун үйлсэд, иргэнийхээ үүргийг биелүүлж явахдаа аймаг нэгт ажилсаг ах эгч үе, тэнгийнхэн та бүгдийнхээ амжилт бүтээлийг сонин сэтгүүлийн хуудаснаас уншиж, радио гоос сонсон дайчин нөхөдөө бахархал болгон ярьж байхад юутай сайхан. Социалист хөдөлмөрийн өргөн фронтоос олон арван баатар, аваргуудад төрүүлсэн хөдөлмөрч сайхан уламжлалтай аймгийнхаа хамт олонд баярлан бахархсан сэтгэлээ илэрхийлэхээр энэ захидлаа бичлээ.

Би тус аймгийн Баяндэлгэр сумын 8 жилийн дунд сургууль төгсч салангаараа ХАА-н үйлдвэрлэлд гарсан бөгөөд манай аймгийн олон алдартны нэг нь БНМАУ-ын хө-

дөлмөрийн баатар, ногоочин С. Бадамсүрэн багш маань надад ногоочны мэргэжлийг эзэмшүүлж ажил хөдөлмөрийн алтан жолоо атгуулсан юм.

Ийм бахархалт уламжлалтай хамт олны итгэл найдварыг биелүүлж цэргийн алба хааж яваада тус аймгийн дайчин бид бахархдаг.

Аймгийнхаа нийт малчин, тариачид, ногоочид, алдарт хөдөлмөрчдөд бүх ард түмний социалист уралдаанд манлайлан уралдахыг хүсэн сэрээж, Баян дэлгэр суманд сууж буй ээж, ногоочин Чулуунхүү, эцэг Лобмбуу, найман дүү нартаа болон, миний үеийн олон нөхдийг минь амьдралын алтан босгоруу бүтээлээрээ дуудсан баатар багш С. Бадамсүрэн, мастер Еаш, үеийн найз нартаа ажил амьдралын сайн сайхныг хүсэн мэндчилж байна.

Ховд аймаг дахь ардын цэргийн ... р агвийн байлдагч Л. Чулуун болон бусад дайчин нөхөд

УРГАЦ САЙТАЙ НУТАГТ

Бүрэн сумын нутаг энэ жил бүхэлдээ гандуу, ургац тачир байгаа учир ургац сайтай байгаа Өндөрширээт сумын нутаг Шуудай дунд нуруу, Дунд говь аймгийн нутаг Борын хөндий зэрэг газруудад хадлангийн 2 бригад гарган ажиллуулж байна.

Хадлангийн ажлыг саатал зогсолтгүй ажиллуулалд үндсэн дээр хүн хүч шатахуун сэлбэг хэрэгсэлээр хангаж өгсний гадна хадланчид өдөрт 50-55 га хадаж, хадсан өвсөө тухай бүрт нь боох, бүхлэх дах ажлыг шуурхайлан

гүйцэтгэж байгаагийн догтор сумын 2 удаагийн аварга хадланч тракторчин Жигмэддорж, хадагч Бадамсүрэн нар өдөрт 25-30 га-гийн өвс хадаж, тарман бусдыгаа хошуучилж байна. Мөн хадагч Дондог 5 морин машин агрегатлан хадлан хадаж нормоо давуулан биелүүлж байна. Ийнхүү хадланчдын нэр их хөдөлмөрийн үр дүнд өвс бэлтгэх төлөвлөгөөг биелүүлэх ба давуулан биелүүлэх бүрэн бололцоотой байна.

Ш. ГАНТӨМӨР

ГУРАВ ДАХЬ УДААГАА ...

Баянцогтын САА-н трактор-комбайнч, БНМАУ-ын Ардын Их Хурлын депутат Д. Очир V таван жилийн төлөөлөгөөний эхний 2 жил 11 сард 5 жил 10 сарын ажил гүйцэтгэж сайхан амжилт гаргажээ.

Д. Очир энэ намрын

тариа хураалтаар 7 дахь жилийнхээ ажилд орж 260 га-гийн тариаг ангиалан хадаж, цайруулалтанд орсон эхний 3 өдөрт КС-4 комбайнаар 62,5 га-гийн 50 тонн вандуй хурааж тогтоосон ургацаас 60 хувиар илүү ургац авсан байна.

Ажлын гараа амжилтын

дүнгээс үзэхэд МАХН-ын гишүүн Д. Очир бүх ард түмний социалист уралдаанд авсан үүргээ амжилттай хэрэгжүүлж БНМАУ-ын аварга комбайнчны бэлэгийг 3 дахь удаагаа хангах итгэл дүүрэн байна.

Д. ДАШ

Мэргэжилтний зөвлөлгөө

ЦАЙРУУЛАХ АППАРАТЫН ТОХИРУУЛГА

Барбаны эргэлт

Цайруулах аппаратад үндсэн хоёр тохируулга байдаг. Ургамлын төрөл, боловсролт, чийгийн их багаас шалтгаалж янз бүрээр тохируулдаг.

Барбаны эргэлт нь минутад буудай 1000—1200, хошуу будаа, арбайд 900—1100, хар будаанд 700—900, вандуй, наран-цэцэгт 400—500 удаа эргэж байх ёстой.

Барбаны эргэлтийг өөрчлөх тохируулгыг гараар гүйцэтгэнэ.

Барбаны дискүүдийн хоорондох зайг үл хөдлөх дискэнд ойртуулах, холдуулах замаар хийнэ.

Дискний хоорондох зайг ихэсгэхийн тулд чангалаар гайкийг адилхан хэмжээгээр суллаж дараа нь боолтыг чангалах

замаар дискний зайг холтгоно. Дискүүдийн зайг өөрчлөхдөө хэмжих багажийг нь хэрэглэх хэрэгтэй. Хэмжүүрийг хэрэглээгүйгээс болж хоёр барбаны нэг шулуун дээр орших байрлал алдагдаж улмаар ремнээ таслах, барбаны голыг муруйлах, тэр ч байтугай барбанаа хагалахад хүргэдэг.

Нэг барбаны дискийг 3 мм ойртуулж нөгөө барбаны дискийг 3 мм холдуулбал барбаны эргэлт минутад 50 орчмоор ихсэх ба багасдаг.

Тохируулсны дараа барбаны боолтуудыг жигд дэс дараатайгаар таван килограмм хүчээр чангалбал зохино.

Хэрэв барбаны эргэлтийг минутад 750-аас цөөн эргүүлэх шаардлага гарвал хоёр барбанаа

сольж тавиад тохируулах хэрэгтэй.

Барбаны эргэлт хэтэрхий хурдасвал тариаг няцлах, ургамлын ишийг жижиглэх ба эргэлт удааширвал тариаг дутуу цайруулдаг учир тохируулгыг зөв хийх шаардлагатай.

Барбан ба декийн хоорондох зайг тохируулах

Барбан декийн хоорондох зайг үндсэн ба туслах гэж хоёр янзаар тохируулна.

Үндсэн тохируулгыг жолооч суудлаасаа удирдан тухайн үед хийнэ.

Үндсэн тохируулгыг хийхдээ доорхи дарааллаар гүйцэтгэнэ.

Эхлээд декийн эксцентрикний барнулыг хөдөлгөлгүй декийг барбанд

ойртуулах замаар тариа орох талд нь 18 мм, гарах талд нь 6 мм байхаар хуваарьтай зураасыг баримтлан тохируулдаг.

Үүний дараа комбайны туслах тохируулга хийдэг гар хөшүүрийг 11 нүх бүхий секторынараас нь тоолон 5 дахь нүхэнд тээглүүлээд түрүүчийн салгасан эксцентрикийн барнулыг буцааж холбоно. Дараа нь декийн дүүжилсэн боолтыг сайтар чангалаад тохируулгын зөв эсэхийг шалгана.

Үүний тулд комбайнчны суудал дээрээсээ тохируулдаг жолооч тав дахь нүхнээс буцааж хамгийн арын нүхэнд тээглүүлнэ. Энэ байдалд декийн хойт хөрчлөх 2 гэсэн, урьд тал нь 14 дэх зураасыг тус тус зааж байх ёстой бөгөөд декийн орох тал 14 мм, гарах тал 2 мм зайтай байна гэсэн үг. Ингээд секторын 11 нүх тутмын хоорондох зай 1 мм-ээр ихсэх бага-

сах ёстойг санаж явцын дунд секторын араас урагш ахиулах замаар туслах тохируулгыг жолооч хийнэ.

Энэ тохиолдолд барбан декийн хоорондох зайг орох талд нь 14—24 мм хүртэл, гарах талд нь 2—12 мм хүртэл ихэсгэж болох юм. Гэхдээ хэвийн хэмжээний болц, чийгтэй тарианд орох талдаа 16—18 мм, гарах талдаа 4—6 мм байхаар тохируулна.

Ер нь барбан декийн хоорондох зай хичнээн бага байх тутам тарианы цайралт сайжрах боловч будаа няцлаж сүрлийг жижиглэх, улмаар цэвэрлэгээний чанарыг муутгадгийг анхаарах хэрэгтэй. Хэрэв будаа цайрагдахгүй түрүүтэйгээр гарч байвал үүл зай холдсоны тэмдэг юм.

Явцын дунд комбайнч барбаны дууг заавал чангааж шалгаж явах хэрэгтэй. Г. БЯМБА-РЕНЧИН



Нэмэлт үүрэг авав

Алтанбулаг сумын «Хөдөлмөр» нэгдлийн Дамдин даргатай үржлийн ферм энэ онд 200 тонн өвс хадах төлөвлөгөөтэйгээс 253 тонн өвс хадаж төлөвлөгөөг 100,1 хувиар биелүүлж сайхан амжилт гаргалаа.

Морин машинаар өвс хадагч Даваажав, Юндэн нар өдөр тутмынхаа нормыг 200—250 хувиар биелүүлж бусдыгаа үлгэрлэн ажиллав.

Одоо тус фермийнхэн 60 тонн өвс төлөвлөгөөнөөс илүү хадах нэмэлт үүрэг аваад ажиллаж байна. Г. ХАЛТАР

Сотинд ирсэн захидал

Хариуцлагагүйн харгай

Баян-өнжүүл сумын «Хайрхан» нэгдлийн «Бүрд» бригад (бригадын дарга нь Гажид, намын хэсгийн ахлагч нь Лхагва) сүүлийн саруудад хүмүүсийн захиалсан хэвлэлийг хүргэж өгөхөө больсон байна. Энэ бригадын сүүний тасгийн саальчид 7 дугаар сарын 10-наас хойших сонингоо аваагүй ажээ. Тэрч байтугай зарим малчдын хэвлэл 4 дүгээр сараас хойш захиалгачдын гар дээр очоогүй байв.

Хөдөлмөрчдийг хохин-

руулж байгаа энэ хариуцлагагүй явдлын бурууг тус бригадын удирдлагууд хэвлэл хүргэгч Бямбын буруу гэж булзааруулж өөрсдөө ч хэвлэлээ олон сараар авалгүй дутагдалтай эвлэрэн суулгааж байна.

Хариуцлагагүй нь хэтэрсэн ийм хүмүүс дээр Баян-өнжүүл сумын нам, захиргааны байгууллага яаралтай арга хэмжээ авч хөдөлмөрчдийг хэвлэлээр хохируулдаг явдлаа эцэс болговол зохино.

Я. ДАМДИНСҮРЭН
Ц. ДАШ

ЯКЕЯМА ДАХИН СЭРЭВ

Японы Якеяма гэдэг галт уул 25 жилийн турш нойрссоноо дахин сэрэв. 2400 метр өндөр энэ галт уулын амсараас 4 цагийн турш үнс чандруу хаяжээ.

Дахин дэлбэрч магадгүй гэж орон нутгийн захиргаа мэдэгдсэн байна.

ТУУЛЫН САВ НУТГААР

Голын Хангай хэмээн нэрлэгдсэн уулын ар биед Чулуут оломын үзэсгэлэнт сайхан зуслан байдаг. Байгалийн сайхан бүрдсэн энэ зусланд Лүн сумын «Энх», «Цагаан уул» бригадын сүүн тасгууд байлаа.

Цэдэв даргатай сүүн тасгийн хамт олон 1974 оны төлөвлөгөөт сүүгээ 101,3 хувиар биелүүлжээ.

Тус тасгийн саальчин сумын 5 удаагийн аварга Наранхүү энэ жил 7500 литр сүү тушаахаас 10340 литр сүү сааж 1975 оныхоо ажилд оржээ.

Наранхүүгийн шавь МХЗЭ-ийн илгээлтийн эзэн Нансалмаа, Баяртунгалаг, Надирмаа, Өлзийжаргал нарын олон сайчууд хамт олноо хошуучилж явна.

Түүнчлэн Сандагсүрэн даргатай саалийн тасгийн Ж. Ичинноров, Жамсран даргатай тасгийн Ч. Дарьдулам, Б. Өлзийжаргал, А. Тэгшжаргал нарын олон саальчид 1975 оныхоо ажилд оржээ.

* * *

Тус сумын дунд сургуулийн сурагчид зуныхаа амралтаар нэгдэлдээ их зүйл бүтээж өгдөг сайхан уламжлалтай. Чулуут Оломын сүүн тасгууд дээр 6—7 дугаар ангийн сурагч Ш. Цээ-

базар, С. Чимэдцэрэн Н. Оюунбилэг нар тус бүр 5—8 үнээ хариуцан сааж 469—670 литр сүү улсад тушаажээ.

Мөн зоодой 430 гаруй, хөмүүлийн дарш 130 гаруй кг-ийг хийсэн байна.

8 дугаар ангийн Гэлэнхүү, Базаррагчаа, 4 дүгээр ангийн Бэрхбаатар нар 473—1048 бухал хийж хадланчдад тусалцжээ. «Энхтуул» нэгдлийн уудам тэнгэр нутгаар явч хад өвлийг өнтэй давахын тулд намрын ажилдаа цаг мөчтэй уралдан шамдсан нэгдэлч олны бүтээл арвин байна.

* * *

Сумын хэмжээгээр хадлангийн 5 бригад гарч одоо төлөвлөгөөнийхөө 70 шахам хувийг биелүүлээд байна.

Хадланчдын дунд зарласан 5—7 хоногийн болзол уралдаанд «Өгөөмөр», «Цагаан уул» бригад тэргүүн байрыг алдгүй явна.

«Өгөөмөр» бригадын хадланчид 500 тонн өвс авах төлөвлөгөөг 50—100 тоннор давуулах зорилготой ажиллаж байна.

Ийнхүү Туулын сав нутгаар хөдөлмөрч олны ажил үйлс өрнөж, амжилт бүтээл арвинтай байна.

Л. БАТСҮХ

ХАРИУЦЛАГАТАЙ ЭРХЛЭГЧИЙГ Б.ЦЭРЭНДАШ

Зарлал

Алтанбулаг сумын харьяат Намсрайжав овогтой Цэрэнпэл нь иргэний 305639 номерын үнэмлэхээ гээгдүүлсэн тул хүчингүйд тооцов.



Намар цаг, адуун сүрэг Б. ЛХАГВА-гийн авсан судалбар гэрэл зураг